



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 24 өдөр

Дугаар Б/11

Ховд

Э.Дөлбадралыг албан тушаалаас нь
чөлөөлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мэргэжил дээшлүүлэн сурах зорилгоор ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн Энхтөрийн Дөлбадралыг 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөр дуусгавар болгон Ховд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Э.Дөлбадралтай санхүүгийн болон бусад холбогдох тооцоо хийхийг тус газрын нягтлан бодогч (Г.Эсбаатар)-д даалгасугай.

3. Ажил хүлээлцэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

ЗАСАГ ДАРГА




Э.БОЛОРМАА

20230324 0344

Zah B/11 Ba

Аймгийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 24-ний өдрийн
Б/11 дүгээр захирамжийн хавсралт



АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Т.Дэлгэрсайхан (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

З.Уянга (Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Б.Болортуул (Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Г.Эсбаатар (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: С.Баярмаа (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)